**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД**

**ЗАВХАН АЙМГИЙН НӨМРӨГ СУМААС БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ**

**НЯМСҮРЭН ОВОГТОЙ ДАШДОНДОВЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Зорилго: Завхан аймгаа өрсөлдөх чадвараараа улсын дундажаас дээш, бага дунд боловсролын чанараараа улсдаа эхний 5-д орох оюунлаг бүтээлч аймаг болгон хөгжүүлнэ.

Үүний тулд доорхи ажлуудыг санаачлан зохион байгуулна.

1. Төрийн үйлчилгээг ард иргэдэд ил тод шуурхай хүргэх ажлыг зохион байгуулж эрчимжүүлэх.
2. Төсөл, хөтөлбөр, зээл, тусламжид хамрагдагсдыг багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж хэвшүүлнэ.
3. Сумын эмнэлгийн тоног төхөөрөмжийг сайжруулж анхан шатны бүх оношлогоог бүрэн хийх арга хэмжээг авна.
4. Архигүй аймаг болох арга хэмжээг зохион байгуулж хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
5. Аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, мэдээлэл хийж Нийтийн биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулж хэвшүүлнэ.
6. Өрхийн үйлдвэрлэл хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
7. Аялал жуулчлалыг хөгжүүлж иргэдийн аялал зуулчлалаас олох орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч ажиллана.
8. Аймаг орон нутагт хийгдэх бүтээн байгуулалтын ажлуудыг нэн чухал хэрэгцээ шаардлагаар нь эрэмбэлж орон нутаг, улсын төсөвт суулгах ажлыг аймаг, Засгийн газар, Их хурлын гишүүдэд уламжлан шийдвэрлэж хэрэгжүүлнэ.
9. Дунд сургуулуудын дотуур байрыг засварлах, байрны хүүхдүүдийн хоол хүнсний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч ажиллана.
10. Улсын болон орон нутгийн чанартай авто замын ашиглалт засварын ажилд салбарын байгууллагын ажлыг хангалттай сайн хийлгэх түүнд хяналт тавих, төсөв мөнгөний асуудалд гойд анхаарч хяналт тавин ажиллах.

ИЮА0110 9039376

БОЛОВСРУУЛСАН: .................................................. Н.ДАШДОНДОВ

УТАС:99199186